

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ
УВС АЙМАГ
Хөгжлийн бодлогын баримт бичиг



УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
2016 – 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
“МАНАЙ УВС”
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Аймгийн ИТХ-ын тогтоол:

Баримт бичгийн үйлчлэх хугацаа:



2016 он

НЭГ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ

Оюунлаг, эрүүл чийрэг бие бялдартай, эрхэлсэн ажилтай, орлоготой, хангалуун амьдралтай “ХҮНИЙ ХӨГЖИЛ”-ийг хангана.

Аймгийн хүн амын өсөлттэй уялдуулан иргэн бүр эрүүл, боловсролтой, ажил орлоготой, амар тайван аж төрөх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.1 Хөдөлмөр эрхлэлт, халамжийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна.

- 1.1.1 Ажилгүй иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, ажлын багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, мал багатай өрхийг дэмжин малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, жилд 200-аас доошгүй шинэ, 500-аас доошгүй байнгын болон улирлын ажлын байр бий болгоно.
- 1.1.2 Ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүд хэрэгжүүлж, жил бүр 500-аас доошгүй иргэнийг түр ажлын байраар хангана.
- 1.1.3 Аймгийн хөдөлмөрийн чуулган зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн эрэлтийн судалгааг 2 жил тутам 1 удаа хийж, хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.1.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл, аюулгүй ажлын байрыг дэмжиж, хөдөлмөрийн тухай хуулийн биелэлтийг 2 жил тутам 1 удаа төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад үзлэг хэлбэрээр зохион байгуулна.
- 1.1.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлэх, бий болсон ажлын байрыг тогтвортой хадгалах бодлого баримтална.
- 1.1.6 Цүнхэгийн амралтанд баригдсан Ахмадын “Алтан үе” сувиллын барилгын дотно, гадна тохижилтын асуудлыг шийдвэрлэж, байнгын ажиллагаатай болгож, цаашид бүс, улсын зэрэглэлтэй болгох асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.
- 1.1.7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилгыг нийтийн халаалтанд холбуулж, шинээр баригдаж буй барилга, бүтээн байгуулалтын ажлуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бий болгох, хуучин барилгууд, явган хүний замыг тэдэнд ээлтэй дэд бүтэцтэй болгон засварлах асуудлыг дэмжинэ.
- 1.1.8 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх асаргаа, сэргээн засалт, сувилахуйн үйлчилгээг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, залуусын хөгжлийн бэрхшээлийг нөхөн сэргээх /брайл бичгийн, бичиг үсгийн, дохионы хэлний, хөдөлгөөн-заслын, хөдөлгөөн-орон зайн чиг баримжаа олгох зэрэг/ сургалт, бэрхшээлийн онцлогт тохирсон мэргэжил олгох сургалтад хамруулахыг дэмжинэ.
- 1.1.9 Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүдийн эрэлт хэрэгцээ, санаачилга боломжид тулгуурласан үйлчилгээг төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран хүргэх замаар жил бүр 200-аас доошгүй өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.

- 1.1.10 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, өрх толгойлсон эцэг, эхчүүдийг дэмжих бодлого баримтална.
- 1.1.11 Аймаг, сумдын ахмадын байрыг ээлж дараатай засварлан, тохижуулж, ахмадын хорооны дарга нарын урамшууллыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 1.1.12 Аймгийн ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд, залуучуудын чуулга уулзалт, зөвлөгөөнийг 3 жил тутамд 1 удаа зохион байгуулна.
- 1.1.13 Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлж, эдийн засгийн идэвхтэй хүн амын 75 хувьд хүргэнэ.
- 1.1.14 Орон гэргүй иргэдийн судалгаа гаргаж, гэржүүлэх асуудлыг судлан үе шаттайгаар шийдвэрлэнэ.

1.2 Эрүүл мэндийн чиглэлээр:

Хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг салбарын тэргүүлэх чиглэл болгон иргэн бүрт эрүүл амьдрах зөв дадал, зан үйлийг төлөвшүүлж, хүний нөөцийн чадавхийг сайжруулан, багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, хүчин чадлыг нэмэгдүүлснээр зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчин, нялхсын эндэгдлийг бууруулж, дундаж наслалтыг уртасгана.

- 1.2.1 Элэг бүтэн Увс, Цахим эрүүл мэнд, НҮЭМ, Сувилахуйн шинэчлэл дэд хөтөлбөр, Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллана.
- 1.2.2 Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.
- 1.2.3 “Баг-83” явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулна.
- 1.2.4 Аймгийн нэгдсэн эмнэлэгт 60 ортой хүүхдийн эмнэлэг, цогцос хадгалах байр, хог хаягдал түр хадгалах байр шинээр барьж, халдвартын тасаг, халаалтын төв шугамын траншейг их засварт, цусны банк, ариутгалын хэсгийг урсгал засварт оруулна.
- 1.2.5 Эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасагт Гемодиализийн хэсэг нээж, эрэгтэйчүүдийн кабинетыг байгуулж хүний нөөц, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.2.6 Завхан, Цагаанхайрхан сумдын ЭМТ-н барилгын их засвар, Өндөрхангай сумын сум дундын эмнэлгийн өргөтгөл, сумын эрүүл мэндийн төвүүдийн сантехникийн засвар үйлчилгээг үе шаттайгаар хийнэ.
- 1.2.7 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилгад өргөтгөл хийж өдрийн болон гэрийн эмчилгээ сувилгаа, уламжлалт нөхөн сэргээх тусламж үйлчилгээ үзүүлнэ.
- 1.2.8 Аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, Сум дундын эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвийн авто машины парк шинэчлэл хийж, Зоонозын өвчин судлалын төвийг хээрийн шинжилгээний тандалт судалгааны мотоциклтой болгоно.
- 1.2.9 Эрүүл мэндийн зарим тусламж үйлчилгээг иргэн, төрийн байгууллага, хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааны оролцоотойгоор хийж салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэн үр дүнг тооцон ажиллана.

- 1.2.10 Баг бүрийг эмчтэй болгон сургаж, чадавхжуулан, унааны асуудлыг үе шаттайгаар шинэчилж “Багийн эмчийн цомог” зөөврийн үзлэгийн байр, утсан сүлжээгээр эргэх холбоо тогтоож ажиллана.
- 1.2.11 Сум дундын эмнэлгүүдийг мэс засал, мэдээгүйжүүлгийн багаж тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангаж, хагалгаа хийх орчин нөхцөлийг бүрдүүлэн, Өмнөговийн сум дундын эмнэлгийг зайн оношилгоонд холбоно.
- 1.2.12 Анхан болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг Эх нярайн цомог, бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сувилал ажиллуулна.
- 1.2.13 Аймгийн эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтнүүдийг урт болон богино хугацааны дотоод, гадаадын сургалтанд үе шаттайгаар хамруулан чадавхжуулж, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтний багийг урилгаар ажиллуулж тэдний туршлагаас суралцана.
- 1.2.14 Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төвийн лабораторийн чадавхыг сайжруулж халдварт өвчин, байгалийн гамшиг, олныг хамарсан осол гэмтлийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай, оновчтой зөв зохион байгуулан, мэдээллийн шуурхай удирдлагын нэгж бий болгон, үр дүнг тооцон ажиллана.
- 1.2.15 Засаг даргын дэргэд Эрүүл мэндийг дэмжих сан байгуулах эрх зүйн орчныг судалж дэмжинэ.
- 1.2.16 Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, уламжлалт болон нөхөн сэргээх эмчилгээний тасгийг өргөжүүлнэ.
- 1.2.17 Жирэмсэн эхийн эрт үеийн хяналтын чанарыг сайжруулж, хожуу хүндрэлийг бууруулж, нялхасын золгүй, гэнэтийн нас баралт, эндэгдлийг үе шаттайгаар багасгаж халдварт өвчнийг бууруулна.

1.3 Боловсролын чиглэлээр:

Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж сургалтын чанарыг сайжруулна.

- 1.3.1 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас сургууль, цэцэрлэг байгуулах болон байгууллагын дэргэдэх стандарт хангасан цэцэрлэг шинээр байгуулах үйл ажиллагааг дэмжиж, сургууль цэцэрлэгийн хүртээмж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
- 1.3.2 “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж эрүүл, баталгаат хоол, хүнс хэрэглэх нөхцөл бүрдүүлж, “Үдийн хоол” хөтөлбөр хэрэгжүүлэх талаар судалж шийдвэрлэнэ.
- 1.3.3 Сургуульд “Биеийн тамирын талбай”, дотуур байранд “Монгол зан үйлийн амьдрах ухааны өргөө”-г үе шаттай байгуулж, цэцэрлэгт “Эцэг эхэд зөвлөгөө өгөх” ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- 1.3.4 “Насан туршийн боловсролын төв”-ийг байгуулж, энэхүү төвөөр дамжуулан олгох сургалтын хүртээмжийг сайжруулж шинэ шатанд гаргана.
- 1.3.5 Аймгийн боловсролын салбарын удирдлага, багш, ажилтны туршлага судлах хөтөлбөрт дотоод, гадаад сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж үр дүнг нь тооцон ажиллана.
- 1.3.6 Сургууль, цэцэрлэгийн хатуу, зөөлөн эдлэл, цэцэрлэгийн хүүхдийн тоглоомыг шинэчлэх, сургуулийн номын санг номоор хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

- 1.3.7 Улаангом сумын Улиасны хэвийн бага сургуулийг хүүхдийн цэцэрлэг болгон тохижуулж, 2, 6-р багийн цэцэрлэгийг орон нутгийн өмчлөлд шилжүүлэх, шинээр баригдах орон сууцны 1 давхрыг хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар ашиглаж болох төлөвлөлт, бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3.8 Улаангом сумын 7, 9, 12-р багт хүүхдийн цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- 1.3.9 Давст, Сагил, Хяргас, Зүүнхангай, Тариалан, Улаангом сумын 2, 3-р цэцэрлэгт өргөтгөл, Баруунтуруун, Цагаанхайрхан, Өндөрхангай, Өмнөговь, Сагил, Өлгий, Улаангом сумын 6, 7-р цэцэрлэгт их засвар хийж, 1, 4-р цэцэрлэгийг бохирын шугамд холбох боломжийг судалж, Өндөрхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн бие засах газрын засвар, Улаангом сумын 3-р цэцэрлэгт сантехникийн засвар хийнэ.
- 1.3.10 Зарим сумдын сургуулийн барилгыг шинээр барьж, Цогцолбор 2-р сургуульд өргөтгөл хийнэ.
- 1.3.11 Хархираа бага сургууль, Өлгий, Хяргас, Зүүнхангай, Ховд, Сагил Наранбулаг, Өндөрхангай сумдын сургууль, Өмнөговийн Улиастай багийн бага сургууль, Тэсийн 1-р бага сургуулийн барилгад /8 жилийн хуучин барилга / их засвар хийнэ.
- 1.3.12 Улаангом сумын “Увс эрдэм” ахлах сургууль, 4-р 10 жил, Тэс сумд сургуулийн дотуур байрны барилгыг шинээр барьж, Бөхмөрөн, Завхан, Улаангом Чандмань-Эрдэм, Баруунтуруун, Өмнөговь, Өндөрхангай, Давст, Сагил, Тариалан, Өлгий сумын ахлах сургуулийн 1, 2-р дотуур байр, Зүүнговь сумын сургуулийн 1, 2-р дотуур байр, Ховд сумын ахлах сургуулийн 1, 2-р дотуур байр, Хяргас сумын ахлах сургуулийн 1, 2-р дотуур байр, Тэс сумын ахлах сургуулийн 1, 2, 3-р дотуур байр, Таван улиасны бага сургуулийн дотуур байранд их засвар хийнэ.
- 1.3.13 Увс эрдэм ахлах сургуулийг төвлөрсөн цэвэр усны шугам сүлжээнд холбоно.
- 1.3.14 “Чандмань-Эрдэм” ахлах сургууль, Тариалан сумын сургуулийн барилгыг барьж ашиглалтад оруулна.
- 1.3.15 Сумдын сургуулийн спорт заалыг шинээр барих, засварлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.3.16 Улаангом сумын Цогцолбор 2, Ахлах 3-р сургуульд хөл бөмбөгийн талбай шинээр байгуулна.
- 1.3.17 Оюуны чадварын спортуудыг хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.
- 1.3.18 Боловсролыг дэмжих сан байгуулах эрх зүйн орчинг судалж дэмжинэ.
- 1.3.19 Аймгийн зарим сумдын сургууль, дотуур, байр, цэцэрлэгүүдийн цахилгаан хангамжийг сайжруулна.

1.4 Соёл, урлагийн чиглэлээр

Иргэдэд хүргэх соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- 1.4.1 Соёл, урлагийн байгууллагын хөгжим, техник хэрэгслийн хангалтыг үе шаттайгаар шинэчилж, аймгийн Ойрад театрт шинэ уран бүтээл туурвихад дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.2 Соёл урлагийн салбарт шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулах, мэргэшүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- 1.4.3 Ойрад түмний соёлыг өвлөн уламжлах, сурталчлах, таниулах, түгээн дэлгэрүүлэх хувийн хэвшил, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, баруун Монголчуудын соёлын дархлааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

- 1.4.4 Угсаатны зүй, зан үйлийн холбогдолтой ном товхимол, цомог, баримтат кино гаргах, түүх соёл, угсаатан судлалын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах, залуу судлаачдыг үе шаттай дэмжинэ.
- 1.4.5 Хөдөөгийн иргэдэд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- 1.4.6 Сумдын соёлын өдрүүдийг Улаангомд, Увс аймгийн соёлын өдрийг Улаанбаатар хотод зохион байгуулж сурталчилна.
- 1.4.7 Биет болон биет бус соёлын өвийг хадгалж, хамгаалах, биет бус өвийг бүртгэн, баримтжуулалтыг цахим хэлбэрт шилжүүлэх, музей, орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг эрчимжүүлэх, сан хөмрөгийн баяжилтад дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- 1.4.8 Музейн болон орон нутгийг судлах танхимын үзмэрт дахин үнэлгээ хийж, эд өлгийн шинэчилсэн дансны үнэ тогтоох, түүх соёлын хөдлөх дурсгал, түүх соёлын үл хөдлөх дурсгалын хяналтын тооллогыг тус тус явуулна.
- 1.4.9 “Харлаг бэйс сүм”-ийг сэргээн засварлаж, аялал жуулчлалын эргэлтэд оруулна.
- 1.4.10 Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 1.4.11 Соёл урлагийн байгууллагын цахилгаан, сантехник болон халаалтын шугамын асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- 1.4.12 Аймгийн төвд стандартын кинотеатр байгуулах ажлыг дэмжинэ.
- 1.4.13 Аймгийн төвд язгуур урлагийн төвийн барилгын ажлыг эхлүүлнэ.
- 1.4.14 Сумдын соёлын төвийн шинэ барилгыг эхлүүлж, их засварын ажлыг хийнэ.

1.5 Спортын чиглэлээр

Нийтийн биеийн тамир болон олимпийн төрлийн спортыг хөгжүүлж амжилтыг ахиулна.

- 1.5.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Пара спортыг хөгжүүлэх, аймгийн шигшээ багтай болох, улс, олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэн, техник, тоног төхөөрөмжөөр ханган ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Бага Олимпийг зохион байгуулна.
- 1.5.2 Улаангом сумд Усан бассейн шинээр барьж, спортын ордонд их засвар хийнэ.
- 1.5.3 Олимпийн төрлийн болон нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор спортын уралдаан тэмцээнийг шат дараалалтай зохион байгуулахыг дэмжиж, аймгийн Засаг даргын нэрэмжит “Аваргын гараа” жүдо, чөлөөт, үндэсний бөхийн тэмцээнийг улирал бүр, аваргуудын нэрэмжит үндэсний бөхийн барилдаан, “Увс дуулиан” хөл бөмбөгийн тэмцээнийг жил бүр зохион байгуулна.
- 1.5.4 Багийн спортыг хөгжүүлэх зорилгоор мэргэжилтэн дасгалжуулагчдыг урьж ажиллуулахад дэмжлэг үзүүлж, шинээр хөгжиж буй байт харваа, бокс, хүндийн өргөлт, дугуй, спортын авиралт, бадминтон, софт теннисний спортын дасгалжуулагч, техник тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг судлан шийдвэрлэнэ.
- 1.5.5 Цэнгэлдэх хүрээлэнг спортын зориулалтаар тоноглох асуудлыг судалж шийдвэрлэн, хөлбөмбөг, цана, тэшүүр, хөнгөн атлетикийн спортыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.6 Спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудтай хамтарч дэмжиж ажиллана.
- 1.5.7 Хүүхдийн оюуны спортын ордон барина.

1.6 Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжиж таатай орчныг бүрдүүлнэ.

- 1.6.1** Сумдын Засаг даргын Тамгын газарт Гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан орон тооны ажилтан ажиллуулна.
- 1.6.2** Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих орчин бүхий “Хүүхэд, залуучуудын ордон” байгуулах асуудлыг судлан шийдвэрлэнэ.
- 1.6.3** Улаангом сумд хөдөлмөр амралтын зуслан ажиллуулна.
- 1.6.4** Бүтэн өнчин хүүхдүүдэд зориулан “Амьдралын гараа” сан нээж, 18 нас хүртэл дэмжлэг үзүүлнэ.
- 1.6.5** Аймгийн Засаг даргын нэрэмжит язгуур урлагийн их наадам, “Авьяас” уралдааныг жил бүр бүсчлэн зохион байгуулна.
- 1.6.6** Баруун аймгуудын хүүхдийн бүсийн чуулганыг 3 жилд 1 удаа, аймгийн хүүхдийн нэгдсэн чуулганыг 2 жилд 1 удаа зохион байгуулж, хүүхдүүдэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэртээ тусгаж ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.6.7** Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.6.8** Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байр, зөвлөгөө мэдээллээр хангах зориулалтын өрөөтэй болж цаашид эмэгтэйчүүдийн хөгжлийн төв байгуулах асуудлыг судлан шийдвэрлэнэ
- 1.6.9** “Залуучуудын Хөгжлийн Төв”-ийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 1.6.10** Оюутан залуучуудыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.6.11** Гэр бүл төлөвлөлт, ялангуяа цус ойртолт, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг баг, сум бүрт зохион байгуулж, өрх бүрт “Угийн бичиг” хөтлөх ажлыг эрчимжүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, аялал жуулчлал, жижиг дунд, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх замаар “ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ” - ийг хангана.

2.1 Хөдөө аж ахуйн хөгжил

- 2.1.1 Мал аж ахуй, газар тариалан хосолсон буюу дагнасан **“ФЕРМЕРИЙН АЖ АХУЙ ХӨГЖҮҮЛЭХ”** өндөр ашиг шимт мал, амьтныг өсгөн үржүүлэхийг бодлогын хүрээнд дэмжинэ .
- 2.1.2 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлж, зарим бүтээгдэхүүнийг экспортод гаргах, мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд бэлтгэн нийлүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.1.3 Хадлангийн нөөц бүхий сумдыг түшиглэн, хадлан тэжээлийн бригад салаа байгуулах, олон наст ургамал тариалах, малын тэжээлийн үйлдвэр байгуулах, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, химийн шинжилгээ хийх, хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 2.1.4 Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлж, шаардлагатай газарт агуулах саравч нэмж барих, улсын нөөцийн Улаангом дахь салбарын агуулахын дээвэр засварлахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.1.5 Мал эмнэлгийн үйлчилгээг дэмжин, халдварт, паразит өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малыг бүрэн хамруулан эрүүлжүүлэх, мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийг итгэмжлэлд оруулж, тоног төхөөрөмж суурилуулах байрны асуудлыг шийдвэрлэх, **“МОНГОЛ МАЛ”** хөтөлбөрийг дэмжиж ажиллана.
- 2.1.6 Баяд үүлдрийн хонь, Өлгийн улаан омгийн ямаа, Тэс хэвшлийн адуу зэрэг нутгийн шилмэл омог, үүлдрийн үржлийн болон өндөр ашиг шимт мал сүргийг өсгөн үржүүлэх, зах зээлд нийлүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.
- 2.1.7 Туслах аж ахуй хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх /гахай, тахиа, туулай, зөгий, загас.../ бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.8 Малчид, малчдын байгууллагын оролцоо, хамтын ажиллагааны үр дүнд бэлчээрийн менежментийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, хөдөлмөрөө хоршиж ажиллах малчдад үйлчлэх, зуучлах хоршоо, нөхөрлөл, бүлэг зэрэг сайн дурын байгууллагуудыг бий болгох малчдад мэдээ, мэдээлэл түгээх, гадаад дотоодын туршлага судлах, жишиг малчин бий болгох ажлыг зохион байгуулна.
- 2.1.9 "Увс түншлэл", "Шилмэл мал" үзэсгэлэн худалдаа, үржлийн малын үнэ хаялцуулах дуудлага худалдаа зохион байгуулж, улс, бүсийн хэмжээнд зохиогдсон үзэсгэлэн яармаг, арга хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулна.
- 2.1.10 Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх, усны эх үүсвэргүй, бэлчээрийн нөөц бүхий газруудад жилд дунджаар 5-с доошгүй гүн өрмийн худаг гаргах, ашиглалтгүй болсон худгийг сэргээн засварлах замаар бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, газрын гарц, бэлчээрийн ургамлын зүйл, түүний бүтцийг сайжруулах зорилгоор хур тунадас нэмэгдүүлэх тусгай загварын газрын генераторуудыг сонгон нийлүүлэх, зохих газруудад суурилуулж ажиллуулна.
- 2.1.11 ХАА-н техник тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэх, МАА-н гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, уламжлалт болон дэвшилтэт техник

технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ. /мах, ноос, ноолуур, арьс шир, сүү сүүн бүтээгдэхүүн.../

- 2.1.12 Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг технологийн шаардлага хангахуйц хүчин чадалтай, ашиглалтын зардал багатай техник, чиргүүл, дүүжин машинаар зуучлан үйлчлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг бодлогын хүрээнд дэмжинэ.
- 2.1.13 Чацаргана тариалалтыг нэмэгдүүлж, зэрлэг чацаргана бүхий сумдын чацарганы талбайг иргэд, хоршоо, нөхөрлөлд хариуцуулж эзэмшүүлнэ.
- 2.1.14 Усалгаатай тариалан, хүлэмжийн аж ахуйг дэмжиж, “ХҮЛЭМЖ”, “ЗООРЬ” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, элит үрийн аж ахуй хөгжүүлэхийг бүх талаар дэмжинэ.
- 2.1.15 Төв суурин газрын бага орлоготой иргэдэд тариалангийн зохих хэмжээний талбайг тодорхой хугацаагаар эзэмшүүлж, гоёлын болон бусад жимс, жимсгэний төрөл бүрийн суулгацын үйлдвэрлэлийг дэмжиж иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.1.16 Улаангомын Арсай, Тээлийн боом, Түргэний Хээр морьт, Баруунтурууны Зүүнтуруунд ус хуримтлуулах далан, услалтын систем барьж эхлүүлэх, зарим услалтын системийг сэргээн засварлах, хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар усалгаатай тариалалтыг нэмэгдүүлэх, дуслын усалгааг үйлдвэрлэлд нэвтрүүлэх бодлогыг дэмжинэ.
- 2.1.17 Үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх, үрийг шинэчлэх, арвин ургац бүхий сортын үр, суулгацыг турших, нутагшуулах, байгаль, цаг уурын нөхцөлд зохицсон чанарын шаардлагад нийцсэн нутгийн болон нутагшсан сортын үр, таримал тэжээл, үр тарианы үрийн нөөц бий болгох, Баруун бүсийн газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнг бодлогоор дэмжинэ.
- 2.1.18 Хүнсний болон бусад бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах зорилгоор стандартчилал хэмжилзүйн хэлтэс, мэргэжлийн хяналтын газрын лабораторийг шаардлагатай суурин болон зөөврийн тоног төхөөрөмжөөр хангана.

2.2 Үйлдвэрлэлийн хөгжил

- 2.2.1 Гаалийн болон бусад төрлийн татварын хөнгөлөлт үзүүлж, ялгавартай бодлого хэрэгжүүлэх замаар аж ахуй, үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг дэмжиж урамшуулах, иргэдэд хязгаарын нэмэгдэл олгуулах зэрэг асуудлыг шийдвэрлүүлэхэд анхаарна.
- 2.2.2 Ашигт малтмалын хайгуул судалгааны ажлыг үргэлжлүүлж, үр дүнг тооцох, аймаг болон сумтай хамтран ажиллах “Гэрээ”-г хэрэгжүүлж ажиллана.
- 2.2.3 “Боршоо” боомтыг олон улсын статустай болгон, дэд бүтцийг сайжруулж, “Аймгийн эдийн засаг-худалдааны төв” байгуулах, ОХУ, БНХАУ болон бусад улсын муж, аймагтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.2.4 Ил тод, хариуцлагатай уул уурхай, ашигт малтмалын бодлогыг эрхэмлэж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологийг ашигласан, орон нутгийн хөгжлийг тэтгэсэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг дэмжинэ.
- 2.2.5 Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, баялаг бүтээгчдийг дэмжин, үйлдвэрлэгчид, хувийн хэвшлийг чадавхжуулахад анхаарах, хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах, тэдний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг орон нутагтаа түлхүү худалдан авах, зах зээлийг өргөтгөх, шинэ техник, технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

- 2.2.6 Суурь судалгаан дээрээ үндэслэн, дотоодын үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлээ оновчтой тодорхойлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, ДНБ-ийг өсгөхөд чиглэсэн ЖДҮ-ийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.2.7 Чацарганыг кластержуулж хөгжүүлэх, боловсруулах үйлдвэрийн технологийг шинэчилж, хүчин чадал, экспортлох бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.
- 2.2.8 Малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үр ашгийг нь тогтвортой өсгөх зорилгоор аймгийн төвд **“МАХ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”** байгуулах, бүтээгдэхүүнийг экспортлох, дайвар бүтээгдэхүүн боловсруулах замаар малчдын орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.2.9 Нутгийн нэрийн бүтээгдэхүүн \цагаан ултай гутал, сүү, цагаан идээ, арвайн гурил, жамц давс, эмээл, гэрийн модон эдлэл, зөөлөн оёдол...\-ий үйлдвэрлэл, нэр төрлийг олшруулах, сав баглаа боодлыг сайжруулан, дотоод, гадаад зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.10 Малын ноос угаах, ээрэх, самнах улмаар боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжиж ажиллана.
- 2.2.11 Орчин үеийн технологид тулгуурласан барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, нэр төрлийг олшруулах, барилгын материалын итгэмжлэгдсэн лаборатори байгуулна.
- 2.2.12 Худалдаа, нийтийн хоол бусад үйлчилгээний газруудын ажил үйлчилгээний стандартыг хэвшүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, сургалт сурталчилгааны ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.13 Сумдад **“АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ”** төв (үсчин, зурагчин, гутал, зурагт, гар утас засвар, оёдлын гэх мэт) ажиллуулах замаар ажлын байрыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.2.14 Увс аймгийн нутаг дэвсгэрт Уул уурхайн компани болон томоохон төсөл хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдэд ханган нийлүүлэх бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний 50-аас дээш хувийг орон нутгийн иргэд, хоршоо, нөхөрлөл, компаниудаар гүйцэтгүүлнэ.

2.3 Хот байгуулалт, дэд бүтцийн хөгжил

- 2.3.1. Улаангом сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлж ажиллах, үйлдвэржилтийн бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон сумдын ерөнхий төлөвлөгөө хийлгэж суурин газрын хаягжуулалтыг шинэчилнэ.
- 2.3.2. Улаангом сумын нутагт “Улаангом” цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
- 2.3.3. Барилгын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, **“АЖЛЫН БАЙР+ГЭР”** хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэж эхлүүлнэ.
- 2.3.4. Шаардлага хангахгүй байгаа барилгажсан хэсгийг болон ашиглалтын хугацаа дууссан хуучин орон сууцыг дахин төлөвлөлтөд хамруулах ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.
- 2.3.5. Хувийн хэвшилд суурилсан тээвэр зуучлалын байгууллагын хүрээг өргөтгөн орон нутаг, хот хоорондын тээврийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж, авто замын хөдөлгөөний удирдлага зохицуулалтын **“УХААЛАГ”** тээврийн систем нэвтрүүлнэ.
- 2.3.6. Аймгийн төвийн авто замын шинэчлэлийг үргэлжлүүлэх, Улаангом-Ховд аймаг болон Улаангом-Улаанбаатарын чиглэлийн хатуу хучилттай замыг барьж дуусгах, төв зам дагууд тээврийн хэрэгслийн хяналтын камер, пост барьж байгуулах, зарим сум, багийн төвийг хатуу хучилттай замаар холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

- 2.3.7. Улаангом сумын зарим ДДТ-ийн хүчин чадлыг нэмэгдүүлж, аймгийн төв, гэр хорооллын инженерийн шугам сүлжээний өргөтгөлийн зураг төслийг хийлгэн, ажлыг үе шаттай хэрэгжүүлэн, амины орон сууцны хороолол бий болох нөхцөл бүрдүүлнэ.
- 2.3.8. Бүс нутгийн чанартай Улаангом - Баруунтуруун чиглэлийн хатуу хучилттай авто зам барих асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- 2.3.9. Увс нуур, Хархираа амралтын чиглэлд хатуу хучилттай зам барьж, цахилгааны эх үүсвэртэй холбох замаар **“ШИНЭ СУУРЬШЛЫН БҮС”** бий болгоно.
- 2.3.10. Шилэн кабель, утасгүй интернэтийн сүлжээг өргөтгөж, төв суурин газрын өрх бүрт хүргэх, Тэс сумыг шилэн кабельд холбох, үүрэн холбооны дахин дамжуулах станцыг шаардлагатай газруудад байгуулна.
- 2.3.11. Улаангомьн гэр хорооллын нарийн гудамжуудыг өргөтгөж, бороо цасны ус тогтоолдог газруудад элс хайрга, шороо асгаж тэгшлэх, гэрэлтүүлэггүй гудамжуудыг гэрэлтүүлэгтэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, авто замын уулзвар болон зарим цэгүүдэд ус зайлуулах суваг, гарц гаргана.
- 2.3.12. Аймаг, сумын төвийн нам даралтын зуухтай хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжийн системд үе шаттай холбох, сумдын төвд нэгдсэн халаалтын сүлжээ байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.3.13. УЦУОШАлбаны барилга барих, хуучин нисэх буудлын барилгыг аймгийн Авто вокзал болгон засварлах, УЦУОШАлбаны чиглэлд гадна дулаан, шугам сүлжээг татаж шийдвэрлэнэ.
- 2.3.14. Баруун бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах 60 МВт-ын цахилгаан станц, дамжуулах шугам сүлжээг байгуулах, аймагт ослын нөөц дизель станцтай болох, сэргээгдэх эрчим хүч, газрын гүний дулааныг хэрэгцээнд нэвтрүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- 2.3.15. Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх зураг төсөв, ТЭЗҮ хийлгэж, барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.
- 2.3.16. Цэвэр усны 2-р эх үүсвэрийн хамгаалалтын зурвас тогтоож, хамгаалалтын зурвасыг чөлөөлөх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, гэр хорооллын худаг, усан санг “Ухаалаг худаг”-т шилжүүлнэ.
- 2.3.17. Улаангом сумын ундны усыг цэвэршүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ..
- 2.3.18. Аймгийн төвийн бохирын тусгай зориулалтын машиныг шинэчилнэ.
- 2.3.19. Орон сууцны хорооллын гадна орчинд хүүхдийн тоглоомын талбай, оршин суугчдын амарч суух газар, ногоон байгууламж бүрдүүлж, шилэн кабельд холбох 2-лсон үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг судлан шийдвэрлэнэ.
- 2.3.20. Орон сууцнуудын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах СӨХ /ОСНАА контор/ байгуулж дэмжлэг үзүүлэх, гудамжуудыг гэрэлтүүлэг бүхий камерын системд холбоно.
- 2.3.21. Гүүр барих, уул давааны зам гаргах, засаж сайжруулах ажлыг судалж, үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.3.22. Хот суурин газрын хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн чанар хүртээмжийг сайжруулж, зарим багийн төвийг төвлөрсөн эрчим хүчний системд холбох ажлыг үе шаттай шийдвэрлэнэ.
- 2.3.23. Улаангом сумын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулж, дэмжлэг үзүүлэх, ачаалал бүхий зам дагууд автобусны буудал нэмж барина.
- 2.3.24. Нийтийн зах орчмын худалдаа, үйлчилгээний газруудыг цэвэр, бохир ус, төвлөрсөн дулааны системд холбох, стандартын худалдааны төв байгуулах ажлыг дэмжинэ.
- 2.3.25. “Дэглий цагаан” нисэх буудалд том оврын агаарын хөлөг хүлээн авах нөхцөл бүрдүүлэх асуудлыг судлан шийдвэрлэнэ
- 2.3.26. Улаангом сумын утааг багасгах ажлуудыг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

- 2.3.27. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж үр ашгийг нэмэгдүүлэн хяналтын механизмыг боловсронгуй болгоно.
- 2.3.28. Сум, багуудын нийтийн халуун усны асуудлыг үе шаттайгаар судлан шийдвэрлэнэ.
- 2.3.29. Зориулалтын мод, нүүрсний зах, түүхий эд, мал нядалгааны нэгдсэн цэгийг байгуулна.
- 2.3.30. Шаардлагатай зам, гүүрүүдэд тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч байрлуулж, гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- 2.3.31. Төрийн байгууллагуудыг онлайн сүлжээнд холбож, видео хурал хийх боломжийг бүрдүүлж холбогдох зардлыг үе шаттайгаар багасгах арга хэмжээ авна.
- 2.3.32. Аялал жуулчлалын бүс, суурин газруудын хог, бохир, дэд бүтцийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 2.3.33. Наранбулаг, Өлгий сум чиглэлийн ЦДАШ, 35кв-ын дэд өртөө шинэчлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- 2.3.34. Улаангом хотын хөгжил цэцэрлэгжүүлэлтийн газрын парк шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.3.35. Өмнөговь сумын 36 айлын орон сууцны барилгыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ашиглалтад оруулна.
- 2.3.36. Улаангом сумын зарим орон сууцнуудын дээвэр засварлах асуудлыг судлан шийдвэрлэнэ.
- 2.3.37. Увс аймгийн зарим хилийн заставуудыг цахилгаан эрчим хүчээр хангана.

2.4 Аялал жуулчлалын хөгжил

- 2.4.1 Аймаг, сумын онцлогт тохирсон аялал жуулчлалын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхээс гадна, үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, онгон байгаль, Увс, Хяргас нуурыг түшиглэн **“ӨВӨЛ, ЗУНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР”**, рашаан сувилал, амралтын газрууд байгуулах асуудлыг судлан, аялал жуулчлалын байгууллагуудыг дэмжиж ажиллана.
- 2.4.2 Аялал жуулчлалын зөвлөгөөн зохион байгуулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, аялал жуулчлалын чиглэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өрхийн түвшинд явагдах эко үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 2.4.3 Аялал жуулчлалын бүс нутгууд болон гол зам маршрутын дагуу түр буудаллах цэгүүд байгуулах, газрыг иргэн, аж ахуйн нэгжүүдэд нээлттэй төсөл сонгон шалгаруулах замаар олгож дэмжлэг үзүүлнэ.
- 2.4.4 Аймгийн үзэсгэлэнт байгаль, түүх соёлын дурсгал, уламжлалт ахуй соёлыг гадаад, дотоодод сурталчлах, мэдээлэл солилцох аялал жуулчлалын цахим вэб сайт, мэдээллийн төвүүдийг ажиллуулах, газрын зураг, брошюр, сурталчилгааны материалыг шинэчлэх, дотооддоо болон олон улсын уулзалт, хамтарсан аялал, үзэсгэлэн яармаг зохион байгуулах ажлыг дэмжинэ.
- 2.4.5 Уулын болон адал явдалт спортын аялал жуулчлалыг хөгжүүлэх, олон улсын шинж чанартай “Увс нуур цом” үндэсний бөхийн барилдаан, “Язгуур урлагийн наадам”, “Чацарганы баяр”-ыг зохион байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.4.6 Аялал жуулчлалын гол бүсүүдэд дэд бүтэц хүргэх асуудлыг үе шаттайгаар судлан шийдвэрлэнэ.

2.5 Төсөв, санхүүгийн бодлого

- 2.5.1 Татварын бааз суурийг өргөтгөж, татвар ногдуулах, хураах үйл ажиллагааг шинэ шатанд гарган, хуулиар тогтоосон эрхийн хүрээнд зарим төрлийн татварын хувь хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан тогтоож, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.5.2 Төсвийн эх үүсвэрийг хамгийн оновчтой, үр ашигтай хуваарилан хэрэгжүүлж, төсвийн ил тод байдлыг хангана.
- 2.5.3 Орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг ил тод болгож, захиалагч, гүйцэтгэгчийн хариуцлага, иргэд олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.
- 2.5.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдүүлж, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.5.5 “Төсвийн сахилга бат- Иргэдийн оролцоо, хяналт” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулан, ногоон орчныг бүрдүүлэх, байгалийн нөөцийн хомсдол, байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулж, “НОГООН ХӨГЖИЛ”- ийн бодлогыг баримталж ажиллана.

3.1 Байгаль орчин, ногоон хөгжил

- 3.1.1 Ногоон хөгжлийн бодлогыг салбар бүрт хэрэгжүүлж, Ногоон аймаг, ногоон сум болох хөдөлгөөн өрнүүлэн, хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй технологи нэвтрүүлнэ.
- 3.1.2 Байгалийн нөөцүүдийн экологи, эдийн засгийн үнэлгээ хийлгэж, түүний нөөцөд тулгуурлан, иргэдийн санал, аймаг орон нутгийн онцлогт тохируулан, нутгийн иргэд, нөхөрлөлүүдэд гэрээгээр эзэмшүүлэх замаар эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулна.
- 3.1.3 Аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх, шинжлэх ухааны ач холбогдол бүхий тусгай цэгүүдийн тоог нэмэгдүүлэн хамгаалалтад авах ажлыг эрчимжүүлнэ.
- 3.1.4 Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалах үйл ажиллагааг дэмжиж, чадавхижуулах ажлыг эрчимжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр орон нутгийн болон бусад төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран ажиллана.
- 3.1.5 Аймаг, сумын хэмжээнд хөрсний доройтол, цөлжилтийн шалтгаан, үр дагаврыг судлан тогтоох, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, цөлжилтөөс сэргийлэх бодлого хэрэгжүүлж ажиллана.
- 3.1.6 Байгалийн гэнэтийн аюулаас (газар хөдлөлт, ой, хээрийн түймэр, хүчтэй салхи шуурга, хортон шавж гэх мэт) урьдчилан сэргийлэх, мэдээллийг орон нутгийн иргэдэд шуурхай хүргэж, байгалийн гамшиг, аюулаас хамгаалах сургалт, сурталчилгааг зохион байгуулна.
- 3.1.7 Хөрс, ус, агаар, усны болон бусад орчны бохирдлыг бууруулах, төв суурин газруудын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг иргэд, аж ахуйн нэгж, сайн дурынхантай хамтран зохион байгуулна.
- 3.1.8 Ойн хөнөөлт шавжийн тархалтын судалгаа, тэмцлийн ажлыг зохион байгуулах, ойн аж ахуйн арга хэмжээ, ойжуулалт, ойн зурвас, ногоон хэрмийн туслах зурвас байгуулах ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.
- 3.1.9 Аймгийн болон ой бүхий 15 сумдын “Ойн менежментийн төлөвлөгөө”-г батлуулж, хэрэгжүүлж ажиллана.
- 3.1.10 Өндөрхангай, Түргэн, Малчин сум дахь сум дундын ойн ангийн болон ойн санг хариуцан хамгаалах, эзэмших нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжин, тэднийг мэргэшүүлэх, сургах, үйл ажиллагааг тогтмолжуулах, урамшуулах замаар ойн зөрчил, хууль бус огтлолт, тээвэрлэлтийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.1.11 Цахилгаан, нарны, хийн, хоргол, үртсэн болон түлээний хэмнэлттэй зуухны ашиглалт, ногоон үйлдвэрлэлийг дэмжих, импортоор оруулж буй барилгын модон материалын хэмжээг нэмэгдүүлэх, унанги, мөчир гишүү, хаягдал модны ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлийн ЖДҮ-г дэмжинэ.
- 3.1.12 Усны тооллогыг орон нутгийн хэмжээнд жил бүр зохион байгуулж, иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах, хот суурин газрын усны бохирдлыг бууруулах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.
- 3.1.13 Усны нөөцийг хамгаалж хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж усан сан, хөв цөөрөм байгуулах, иргэд, нөхөрлөлийн хүчээр

булаг шандын эхийг хамгаалах тохижуулах, эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.

- 3.1.14 Усны хатуулаг ихтэй болон цэвэршүүлэх шаардлагатай ундны ус бүхий сумдын төвийн гүн өрмийн худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах, гэр хорооллын худгуудын энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, тоолууржуулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлнэ.
- 3.1.15 Хамгаалалтын захиргаадын үйл ажиллагааг дэмжиж, байгаль хамгаалагчдыг бие хамгаалах хэрэгсэл, унаа, багаж төхөөрөмж, хувцас, цасны мотоцикль, завь, нэг загварын ажлын байраар хангах, газар нутгийг нь тэмдэгжүүлэхэд анхаарна.
- 3.1.16 Ан агнуурын менежмент төлөвлөгөөг хэрэгжүүлэх, загас, агнуурын амьтан, байгалийн ургамлын нөөцийн судалгаа хийж, биологийн төрөл зүйлийн нөөцийг нэмэгдүүлэх, ашигт болон нэн ховор, ховор ургамлыг тарималжуулах ажлыг өргөжүүлнэ.
- 3.1.17 Улаангом сумд эхэлсэн хогийн менежментийн үйл ажиллагааг дэмжиж, хог хаягдал ангилан ялгаж боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг дэмжинэ.
- 3.1.18 Сумдын хог хаягдлын менежментийг сайжруулах, хатуу болон химийн хог хаягдлыг төрөлжүүлэн ангилах, дахин боловсруулах, тээвэрлэх, устгах, булах, технологийн шинэчлэлт хийх ажлуудыг зохион байгуулалтанд оруулж, зохистой хэрэглээг амьдралд хэвшил болгох ажлуудыг шат дараатай хэрэгжүүлнэ.
- 3.1.19 Байгалийн баялаг ашиглан үйл ажиллагаа явуулдаг, байгалийн баялаг ашиглах \ашигт малтмал, ус, барилгын материал...г.м\ гэрээ, төлөвлөгөөтэй ажилладаг аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны аудит болон мэргэжлийн байгууллагын мониторинг, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээг хуулийн хугацаанд тогтмол хийлгэж хэвшүүлнэ.
- 3.1.20 Уул уурхайн дүйцүүлэн хамгааллын төслийг үе шаттай хэрэгжүүлэхэд аймаг орон нутгийн оролцоог нэмэгдүүлж, бичил уурхайн үйл ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу дэмжиж, зохион байгуулалтад оруулна.
- 3.1.21 Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг сайжруулах, эвдэрч эзэнгүй орхигдсон газрын тооллогыг жил бүр хийж, нөхөн сэргээлгэх болон дүйцүүлэн хамгаалах ажилд төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр бичил уурхайн нөхөрлөл, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.1.22 Түгээмэл тархацтай ашигт малтмалын хууль бус олборлолтыг зогсоох, батлагдсан нөөцөд тулгуурлан, орд карьерийг эзэмшүүлэх, ашигласны төлбөр үнэлгээг шинэчлэн мөрдүүлнэ.

ДӨРӨВ: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1 Засаглалын бодлого:

Тогтвортой , хариуцлагатай , ил тод, төрийн албыг төлөвшүүлнэ.

- 4.1.1 Төрийн албаны бүх шатанд шударга, ил тод, хариуцлагын тогтолцоо бий болгож, төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнуудыг нийгмийн шударга ёсны зарчмыг үйл ажиллагаандаа тууштай баримтлан хуулийн хүрээнд ажиллуулна.
- 4.1.2 Төрийн захиргааны болон нутгийн удирдлагын тогтолцоог оновчтой бүтэцтэй болгож, төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангана.
- 4.1.3 Төрийн албан хаагчдыг мэдлэг, туршлага, ур чадвараар нь сонгон авдаг журмыг мөрдөж, чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлж, “Төрийн албан хаагчдыг чадваржуулах” дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлнэ.
- 4.1.4 Төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх танхимын болон зайн сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлж, төрийн албаны мэргэшсэн, чадварлаг байх нөхцөлийг дэмжинэ.
- 4.1.5 Аймгийн Засаг даргын тамгын газарт “Чанарын удирдлагын ISO 9001:2015” стандартыг хэрэгжүүлж, сумдын ЗДТГ, агентлагт хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж чанарын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.1.6 Аймгийн ЗДТГ, сумдын тамгын газар, агентлагийн техник тоног төхөөрөмжийг үе шаттайгаар сайжруулж, цахим засаглалыг хэрэгжүүлж ажиллана.
- 4.1.7 Төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, хүнд суртал, чирэгдлийг арилгаж, үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэн, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.
- 4.1.8 Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах, бодлого шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг тусгах, ил тод байдал, оролцоог дэмжиж иргэдээ дээдэлсэн нээлттэй хариуцлагатай хяналттай төрийн үйлчилгээ бий болгоно.
- 4.1.9 Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх бодлого баримталж, 4 талт түншлэлийг хөгжүүлэх бодлогыг дэмжин ажиллана.
- 4.1.10 Аймгийн сумдын нутгийн захиргааны ордон шинээр барих ажлыг ээлж дараатай хийж гүйцэтгэнэ.
- 4.1.11 Сумдын Засаг даргын Тамгын газрын байрын барилгын засвар тохижилт, авто машины парк шинэчлэлт, Багийн Засаг дарга нарыг унаажуулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 4.1.12 Төрийн албан хаагчдыг хөнгөлөлттэй үнээр орон сууцтай болгох, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.1.13 Баруун бүс нутгийн хөгжлийн бодлогыг дэмжиж, хамтын ажиллагааг сайжруулж, тэргүүлэх чиглэлээр хамтарч ажиллана.
- 4.1.14 Хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ-ын муж, улс, аймгуудтай бүх салбарт харилцааг гүнзгийрүүлэхээс гадна ОХУ-ын Сибирийн тойргийн бусад муж улсуудтай шинээр харилцаа тогтоож худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.
- 4.1.15 Гадаад худалдааны тааламжтай нөхцөлийг бүрдүүлж, орон нутгийн чанартай бараа бүтээгдэхүүнийг хөрш зэргэлдээ бүс нутгуудад нийлүүлэх боломжийг судлан шийдвэрлэх, хил орчмын худалдааг хөнгөвчилж, хилийн

боомтын дэд бүтцийг сайжруулж, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор иргэдийн чөлөөтэй зорчих нөхцөлийг сайжруулна.

- 4.1.16 Бусад улс орнуудын хот, мужуудтай харилцааг өргөжүүлж боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон бусад салбарын төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, төрийн албан хаагчдыг гадаадын улс орнуудад урт, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.
- 4.1.17 Статистик мэдээлэл, тооллого түүвэр судалгааг хугацаанд нь түргэн шуурхай зохион байгуулж мэдээллийг нээлттэй ил тод байлгах нөхцлийг бүрдүүлэн хүн ам, орон сууцны 2020 оны тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулж хүн ам, өрхийн мэдээллийн сангийн чанарыг сайжруулна.

4.2 Хууль, эрх зүйн хөгжил

Хууль хяналтын байгууллагуудтай хамтарч иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

- 4.2.1 Иргэдийн хууль, эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх, сум, байгууллагуудад зохион байгуулах эрх зүйн сургалт, сурталчилгааны зардлыг шийдвэрлэх, эрх зүйн боловсролын дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.2.2 Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.
- 4.2.3 Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид тавих хяналтыг сайжруулна.
- 4.2.4 Аймгийн хэмжээнд бүсчилсэн байдлаар тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгдсэн зөвлөгөөнийг жил бүр, хөрш зэргэлдээ Тува улсын хуулийн байгууллагуудтай хамтарсан зөвлөгөөн уулзалтыг 2 жилд 1 удаа зохион байгуулна.
- 4.2.5 Өндөрхангай, Давст, Баруунтуруун, Бөхмөрөн, Түргэн сумдын цагдаагийн бичил байрыг засварлах, Тэс, Цагаанхайрхан, Өмнөговь сумдад цагдаагийн бичил байр барих, цагдаагийн байгууллагыг шаардлагатай техник хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлнэ.
- 4.2.6** Гэмт хэрэг зөрчлийн гаралтыг бууруулахад анхаарч, аймгийн хэмжээнд олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулах асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.2.7 Улаангом сумын гудамжны камержуулалтыг нэмэгдүүлэх, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулна.
- 4.2.8 Хил орчмын сумдын “Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлүүдийн ажлыг эрчимжүүлнэ.
- 4.2.9 Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, алдагдсан малыг олох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хил орчмын сумдын бод малыг сум сумаас нь ялгагдах баталгаажсан тамгатай болгож, нэгдсэн бүртгэлд оруулна.
- 4.2.10 Шүүх шинжилгээний албыг лабораторийг шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх, дуудлагад явах, цогцос зөөвөрлөх зориулалтын автомашинтай болгоно.
- 4.2.11 Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримт бичгийг цахимжуулна.
- 4.2.12 Төрийн архивын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг хангасан зориулалтын байрыг барих, Архивын зориулалтын нягтруулсан шүүгээгээр хангах, шаардлагатай техник хэрэгслийг шинэчлэн сайжруулна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2016 оны .. сарын .. –ний өдрийн
../.. дугаар тогтоолын-дүгээр хавсралт

УВС АЙМГИЙГ 2016- 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН
ЖАГСААЛТ

	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийг	
		Үргэлжлүүлэх	Шинээр хэрэгжүүлэх
1	Увс аймгийг хөгжүүлэх хэтийн зорилт боловсруулах		
2	“Манай баг” гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх хөтөлбөр		
3	“Ажлын байр + гэр” хөтөлбөр		
4	“Аялал жуулчлал” хөтөлбөр		
5	“Малжуулах” хөтөлбөр		
6	“Мах” хөтөлбөр		
7	“Хүлэмж” хөтөлбөр		
8	“Зоорь” хөтөлбөр		
9	“Чацаргана-2” хөтөлбөр		
10	“Боловсролыг дэмжих” хөтөлбөр		
11	“Эрүүл мэндийг дэмжих” хөтөлбөр		
12	“Ахмадыг дэмжих” хөтөлбөр		
13	“Хүүхэд, залуучуудыг дэмжих” хөтөлбөр		
14	“Жендерийн тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөр		
15	“Төсвийн сахилга бат - Иргэдийн оролцоо, хяналт” хөтөлбөр		
16	“Эрх зүйн боловсрол” дэд хөтөлбөр		
17	“Төрийн албан хаагчдыг чадавхжуулах” хөтөлбөр		
18	“Спортыг дэмжих” хөтөлбөр		

19	“Увс хүн хөгжлийн хөтөлбөр” загвар		
20	“Монгол хэл бичгийн ” хөтөлбөр		